



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛЬ



Төрийн захирлын тушаал
дүрмийн дагуу

ДОКТОРАНТЫН ХУВИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ДОКТОРАНТЫН ХУВИЙН АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар хот
2022 он

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬД
СУРАЛЦАХ ГЭРЭЭ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Суралцах гэрээг нэг талаас ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, төвийг төлөөлж захирал
. . . овогтой , нөгөө талаас овогтой
/цаашид “докторант” гэх/ нар харилцан тохиролцож МУ-ын “Боловсролын тухай” хууль, ШУТИС-ийн докторантурын сургалт эрхлэх дүрэм, журмыг үндэслэн харилцан тохиролцож энэхүү сургалтын гэрээг байгуулав.

1.2 Сургууль, суралцагч хоёрын харилцааг МУ-ын “Боловсролын тухай” хууль, бусад хууль тогтоомж, ШУТИС-д мөрдөгдөж буй дүрэм, журамд тулгуурлан энэхүү гэрээгээр зохицуулах бөгөөд тэдгээрт заагдсан үүргийг хоёр тал адил хүлээнэ.

1.3. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль /төв/ -д элсэх болзлыг хангасан овогтой -ийг тус сургууль /төв/-ийн докторантурын сургалтанд /өдрийн/ F индекс бүхий хөтөлбөрөөр суралцуулахаар тохиролцов.

1.4. Кредитийн төлбөрийг ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, төвийн банкны тоот харилцах дансанд шилжүүлгээр төлөн тооцоог хийх болно.

Хоёр. Холбогдох нэгж, бүрэлдэхүүн сургууль, төвийн хүлээх үүрэг

2.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон докторын сургалт эрхлэх зөвшөөрөл авсан хөтөлбөрийн дагуу суралцуулах, сургалтын үйл ажиллагааг зохион явуулах, докторын зэрэг олгох, нөхцөл бололцоогоор хангах;

2.2. Суралцах хугацаанд суралцагчийг хичээлийн байр, номын сан, интернетээр зохих журмын дагуу ханган үйлчлэх;

2.3. Сургалт явуулахад зайлшгүй шаардагдах сургуулийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, компьютерийн лаборатори, сургалтын материалыг үнэ төлбөргүй ашиглуулах;

2.4. Бүрэлдэхүүн сургууль, төв дээр докторын хичээл заадаг бүх багш нар докторын зэрэгтэй байх шаардлагыг хангаж ажиллуулах;

2.5. Суралцагч нэг бүрт эрдэм шинжилгээний ажлын удирдагч, зөвлөх комиссын гишүүн /хоёр/-ийг тус тус томилох;

2.6. Сургалтын төлөвлөгөөг сургалтын чиглэл бүрээр салбар (тэнхим) боловсруулан, сургалтын төлөвлөгөөний дагуу хичээл бүрийг тасралтгүйгээр чанарын өндөр түвшинд явуулах;

2.7. Суралцагчийн хүсэлтийг үндэслэн шилжилт хөдөлгөөний асуудлыг Эрдэм шинжилгээ, инновацын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх;

2.8. Докторантурын сургалтыг дүүргэсэн, туршилт судалгааны ажлын 50-иас доошгүй хувийг гүйцэтгэсэн, мэргэжлийн нэгдсэн шалгалт өгсөн докторантад сургалт дүүргэсэн гэрчилгээг Эрдэм шинжилгээ, инновацын газраас олгоно.

2.9. Докторын диссертацийн ажлыг хамгаалахад тавигдах шаардлагыг бүрэн биелүүлсэн докторантыг төгсөлтийн судалгааны ажлыг хамгаалуулах нөхцөл бололцоогоор хангах;

2.10. Докторын зэргийг амжилттай хамгаалсан горилогчид докторын зэрэг, диплом олгохыг ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулж, докторын диплом олгоно.

Гурав. Сургуулийн эрх

3.1. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдээс суралцагчдад сонгон суралцах боломжийг олгох;

3.2. Сургалтын явц, үр дүнгийн талаар суралцагчаас тухай бүр мэдээ, тайлан гаргуулж авах, гэрээний үүргийг биелүүлэх талаар шаардах, зөрчил, дутагдлыг арилгах талаар түүнд анхааруулах, шаардлага тавих;

3.3. ШУТИС-ийн докторын сургалт явуулах үйл ажиллагаа, журамд заасан үүрэг хариуцлагуудыг удаа дараа биелүүлээгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр аттестатчлалд хамрагдаагүй, 4 улирал дараалан

сургалтад хамрагдаагүй тохиолдолд сургуулийн холбогдох журмын дагуу суралцагчийн гэрээг цуцлах;

3.4. Сургалтын төлбөрийг хугацаанд нь төлөх шаардлага тавих;

3.5. Их сургууль зах зээлийн эдийн засгийн инфляцийн түвшингээс хамааруулан тухайн хичээлийн жилийн докторантурын сургалтын төлбөрт өөрчлөлт оруулах эрхтэй.

Дөрөв. Суралцагчийн хүлээх үүрэг

4.1. Хичээлийн нэг улиралд 9-12 кредитийн хичээл сонгож хэвийн ачаалалтай, 12-15 кредит сонгож хэт их ачаалалтай байх бөгөөд хэт их ачааллыг салбарын профессорын зөвшөөрлийг үндэслэн суралцагчийн авъяас чадвар, бэлтгэлээс хамааруулан нэг улиралд 3 хүртэлх багц цагийн хичээл нэмж үзэх зөвшөөрлийг олгоно.

4.2. Сургалтын нэгдсэн хуанлид заасан хугацааны дагуу хичээл сонголт 1, 2-ыг хийх;

4.3. Сургалтын хөтөлбөрийн агуулгыг докторантурын сургалтын 3-5 жилийн хугацаанд багтаан бүрэн гүйцэтгэх;

4.4. Суралцагч энэхүү суралцах гэрээний 1.4-д заасны дагуу сонголт 2-г баталгаажуулахын өмнө сургалтын төлбөрийг төлсөн байх;

4.5. Суралцагч нь “Шинжлэх ухаан, технологийн их сургуульд магистр, докторын сургалт зохион байгуулах, зэрэг хамгаалахад баримтлах журам”-ын дагуу үүргээ биелүүлэх, докторантын ёс зүйн хэм хэмжээг чандлан баримтлах;

4.6. Суралцагч нь “Магистр, доктор оюутны сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажил”-ын хүрээнд бүрэлдэхүүн сургууль, төв дээр сургалт, судалгааны ажлын явцыг тайлагнаж байх;

4.7. Судалгаа шинжилгээний ажлыг мэргэжлийн түвшинд хийж гүйцэтгэх, бие даан идэвхи санаачлагатай ажиллах, сэдвийн дагуу төсөл, аж ахуйн гэрээт ажилд оролцох;

4.8. Хичээлийн жилд докторантын сургалт, судалгааны ажлын түвшинг хоёр удаа тогтоох бөгөөд суралцагч нь тухайн хичээлийн жилд сонгож суралцсан хичээлийн дүн, цуглуулсан кредит, сургалт, судалгааны ажлын явцаа тухайн салбарын хурлаар хэлэлцүүлэх;

4.9. Судалгааны ажил, эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд оюуны өмчийн хуулбарлалтын програмыг ашиглан, хуулбарлалтын хувь хэмжээг тогтоолгож, судлаачийн ёс зүйг эрхэмлэж байх;

4.10. Судалгаа шинжилгээний ажлыг шинжлэх ухааны түвшинд боловсруулан бичиж, сургалтын хугацаанд багтаан докторын зэрэг хамгаалах;

4.11. Суралцагч нь докторантын хувийн ажлын төлөвлөгөөний дэвтрийг тогтмол хөтөлж, холбогдох газар, салбар, профессор, удирдагчаар тус тус баталгаажуулах.

Тав. Суралцагчийн эрх

5.1. Сургалтын болон сурах орчин нөхцлийн чанарыг сайжруулах хүсэлт гаргах, суралцах нөхцөл бололцоогоор хангуулах, боловсролын зэргээ ахиулах;

5.2. Хууль тогтоомж, холбогдох журамд заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх зэрэг гэрээнд заасан бусад нөхцөлүүдээр хангах талаар шаардах;

5.3. Суралцагч нь суралцах хугацаандаа сургуулиас зохион байгуулагдсан уралдаан тэмцээнд оролцох, гадаад, дотоодын их, дээд сургуульд шилжин суралцах;

5.4. Суралцагч нь хүндэтгэх шалтгааны улмаас 1 сараас дээш хугацаагаар хичээлд сууж чадахгүйд хүрвэл чөлөө хүссэн өргөдөл гаргах;

5.5. Суралцагч нь чөлөөг сунгах буюу дахин олгох тухай хүсэлтийг бичгээр гарган үргэлжлүүлэн чөлөө авч болох бөгөөд сургалтаас чөлөөтэй байх нийт хугацаа 1 жилээс хэтрэхгүй байх;

5.6. Сургалтын хөтөлбөрийн дагуу явуулж буй мэргэжлийн болон мэргэшүүлэх, сонгон судлах хичээлүүдийн талаар санал гаргах, профессор, багш нарын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар гомдлоо илэрхийлэх, шаардлага тавих.

Зургаа. Санхүүгийн тооцооны талаар

6.1 Суралцагч албан ёсоор төлбөрөө төлж тухайн улиралд суралцах хичээлээ хугацаанд нь сонгон баталгаажуулсан нөхцөлд улирлын төлбөрийн хэмжээнд өөрчлөлт орохгүй;

6.2 Хэрэв суралцагч хичээлийн жилийн тухайн улирлын эхний 5 долоо хоногийн дотор гэрээг цуцлах хүсэлтээ гаргасан тохиолдолд гэрээг цуцлах буюу зохих төлбөрийг буцаан олгоно.

6.3 Дээрх хугацаанаас хойш буюу суралцагч нь үзвэл зохих хичээлээ сонгон хүндэтгэх шалтгаангүйгээр тухайн хичээлийн жилдээ тодорхой кредитийг цуглуулаагүй нэг жил болсон тохиолдолд сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.

6.4. Хэрэв суралцагч нь сургалтаас хүндэтгэх шалтгааны улмаас чөлөө хүссэн тохиолдолд сургалтын төлбөрийн үлдэх хэсгийг дараагийн улирал /жил/-д шилжүүлэн тооцож болно.

Долоо. Гэрээг цуцлах нөхцөл

7.1. Суралцагч нь хичээлийн жил эхэлсэнээс хойш 15 хоногийн дотор бүртгүүлээгүй, сургалтын үйл явцыг хаяж хүндэтгэх шалтгаангүйгээр 1 улирлын турш сураггүй болсон тохиолдолд сургуулиа орхисон гэж үзэх;

7.2. Чөлөөний хугацаа дуусаад тогтсон хугацаанд ирж бүртгүүлээгүй буюу чөлөөг сунгах тухай өргөдлөө албан ёсоор гаргаагүй;

7.3. Суралцах нийт хугацаанд мэргэжлийн хичээлд хангалтгүй (84-өөс доош) дүн авах, цуглуулбал зохих нийт кредитийг авч чадаагүй;

7.4. Тогтоосон хугацаанд сургалтын төлбөрөө төлөөгүй;

7.5. Гэмт хэрэг, ёс суртахууны ноцтой зөрчил гаргасан нь нотлогдсон тохиолдолд гэрээг цуцлана.

Найм. Гэрээний хүчинтэй байх хугацаа

8.1. Энэхүү гэрээг талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчинтэйд тооцно.

8.2. Гэрээг мөрдөх явцад түүнд өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, холбогдох өөрчлөлтийг нэмэлт заалтаар оруулж болно.

8.3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, докторантад хувийн ажлын төлөвлөгөөний дэвтэр, бүрэлдэхүүн сургууль /төв/-ийн сургалтын албанд гэрээний нэг хувь тус тус хадгалагдана.

8.4. Гэрээний талууд гэрээг цуцлах санал тавиагүй бол уг гэрээг өмнөх хугацаагаар сунгасанд тооцно.

Ес. Талуудын хүлээх хариуцлага

9.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, сургууль, ажилтанд эд материал, сэтгэл санааны хохирол учруулж, дарамт шахалт үзүүлсэн, хариуцлагагүй ажиллагаа явуулсан нь холбогдох байгууллагаар шалгагдан тогтоогдсон бол буруутай тал нь зохих хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу хариуцлага хүлээж, гарсан хохирлыг бүрэн барагдуулна.

СУРГАЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Бүрэлдэхүүн сургууль, төвийг төлөөлж:

Захирал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга

Докторант

/гарын үсэг/

/гарын үсэг/

/гарын үсэг/

Гэрээ байгуулсан он сар өдөр



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦЫН ГАЗАР

Сургууль (төв)-ийн нэр _____

Салбар (тэнхим)-ийн нэр _____

ДОКТОРАНТЫН ХУВИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Овог, нэр _____

Сурах хөтөлбөрийн нэр, индекс _____

Судалгааны ажлын сэдвийн нэр (диссертаци) _____

(сэдвийг Захирлын тушаалаар батлагдсаны дараа тушаалын дугаар, он сар, өдрийн хамт бичнэ).

Докторантурт элссэн он, сар, өдөр

(Докторантурт элссэн тушаалын дугаар, он сар, өдрийн хамт бичнэ).

Судалгааны ажлын удирдагч _____

(овог нэр, эрдмийн зэрэг, цол)

Суралцах хугацаа _____

ДОКТОРАНТЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН СЭДВИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Судалгааны ажлын удирдагч

(гарын үсэг)

Докторант

(гарын үсэг)

ДОКТОРАНТЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН СЭДЭВ ӨӨРЧЛӨГДСӨН БАЙДАЛ

д/д	Өмнө батлагдсан сэдвийн нэр	Сэдвийн өөрчлөгдсөн нэр	Өөрчлөх болсон шалтгаан	Тушаалын дугаар, он, сар, өдөр
1				
2				
3				
4				

ДОКТОРАНТЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАГЧ, ЗӨВЛӨХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН ӨӨРЧЛӨГДСӨН БАЙДАЛ

д/д	Өмнө батлагдсан удирдагч, зөвлөх комиссын гишүүний нэр, эрдмийн зэрэг, цол	Өөрчлөгдсөн удирдагч, зөвлөх комиссын гишүүний нэр, эрдмийн зэрэг, цол	Өөрчлөх болсон шалтгаан	Тушаалын дугаар, он, сар, өдөр
1				
2				
3				
4				

АЖЛЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажлын нэр	Ажлын товч агуулга, багтаамж	Гүйцэтгэх хугацаа	Тайлагнах хэлбэр
Мэргэжлийн хичээлийн сургалт	1. Заавал үзвэл зохих мэргэжлийн хичээл 2. Сонгон суралцах мэргэжлийн хичээл		
Судалгааны ажил	1. Онолын 2. Туршилтын		
Эрдэм шинжилгээний бүтээл			
Зөвлөх комисс, салбар (тэнхим), Эрдмийн зөвлөлийн хурлаар судалгааны ажлыг хэлэлцүүлэх хугацаа			

Докторант

_____ (гарын үсэг)

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч

_____ (гарын үсэг)

\

20 он сар өдөр

СУРГАЛТЫН НЭГ ДЭХ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажлын нэр	Ажлын товч агуулга, багтаамж
Докторантын үзвэл зохих мэргэжлийн хичээлийн шалгалт өгсөн байдал	1. Заавал үзвэл зохих мэргэжлийн хичээл 2. Сонгон суралцах мэргэжлийн хичээл
Судалгааны ажил	1. Онолын 2. Туршилтын
Эрдэм шинжилгээний бүтээл (нийтлүүлсэн өгүүлэл)	
Бусад ажлын хэлбэр	

Докторантын талаарх удирдагчийн үнэлгээ, дүгнэлт _____

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч _____
 (гарын үсэг)

Докторант _____
 (гарын үсэг)

20 он сар өдөр

Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа	Салбарын профессор, эрдэм шинжилгээний ажлын удирдагчийн тэмдэглэл

Докторант _____
(гарын үсэг)

Аттестатчлалд орсон хугацаа _____

протокол № _____

Салбар (тэнхим)-ийн эрхлэгч, профессор: _____
(гарын үсэг)

20 он сар өдөр

СУРГАЛТЫН ХОЁР ДАХЬ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажлын нэр	Ажлын товч агуулга, багтаамж
Докторантын үзвэл зохих мэргэжлийн хичээлийн шалгалт өгсөн байдал	1. Заавал үзвэл зохих мэргэжлийн хичээл 2. Сонгон суралцах мэргэжлийн хичээл
Судалгааны ажил	1. Онолын 2. Туршилтын
Эрдэм шинжилгээний бүтээл /нийтлүүлсэн өгүүлэл/	
Бусад ажлын хэлбэр	

Докторантын талаарх удирдагчийн үнэлгээ, дүгнэлт _____

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч _____
 (гарын үсэг)

Докторант _____
 (гарын үсэг)

20 он сар өдөр

Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа	Салбарын профессор, эрдэм шинжилгээний удирдагчийн тэмдэглэл

Докторант _____
(гарын үсэг)

Аттестатчлалд орсон хугацаа _____

протокол № _____

Салбар (тэнхим)-ийн эрхлэгч, профессор: _____
(гарын үсэг)

СУРГАЛТЫН ГУРАВ ДАХЬ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ажлын нэр	Ажлын товч агуулга, багтаамж
Докторантын үзвэл зохих мэргэжлийн хичээлийн шалгалт өгсөн байдал	1. Заавал үзвэл зохих мэргэжлийн хичээл 2. Сонгон суралцах мэргэжлийн хичээл
Судалгааны ажил	1. Онолын 2. Туршилтын
Эрдэм шинжилгээний бүтээл (нийтлүүлсэн өгүүлэл)	
Бусад ажлын хэлбэр	

Докторантын талаарх удирдагчийн үнэлгээ, дүгнэлт _____

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч _____
 (гарын үсэг)

Докторант _____
 (гарын үсэг)

Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа	Салбарын профессор, эрдэм шинжилгээний удирдагчийн тэмдэглэл

Докторант _____
(гарын үсэг)

Аттестатчлалд орсон хугацаа _____

протокол № _____

Салбар (тэнхим)-ийн эрхлэгч, профессор: _____
(гарын үсэг)

20 он сар өдөр

**БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ (ТӨВ)-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ШИЙДВЭР**

Докторант _____

сэдэвт эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг _____

(бүрэн/бүрэн бус)

гүйцэтгэсэн болно.

Докторант _____

_____ сэдвээр докторын (Ph.D)-ын диссертацийг

докторын ажил хамгаалуулах зөвлөлд хамгаалалт хийлгүүлэхээр хүргүүлэв.

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ (ТӨВ)-ИЙН
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

(гарын үсэг)

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН УДИРДАГЧ

(гарын үсэг)

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦЫН ГАЗРЫН ДАРГА

(гарын үсэг)

ДОКТОРАНТ-НЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

[illegible]

Тэмдэглэл

[illegible]